



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

V ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хурлыг 2021 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 16.00 цагт Төрийн ордон дахь Их танхимд 87 хувийн ирцтэй хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. "Нэг хаалга-Нэг шинжилгээ" арга хэмжээний явц, шинжилгээний сорьцийн хадгалалт, тээвэрлэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;

*Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд,*

2. "Хязгаарлалтын дэглэм тогтоож, хэв журам сахиулах" ажлын хэсгийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;

*Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга,  
цагдаагийн хурандаа Ж.Амгалан*

3. "Хангалт, зохион байгуулалт хариуцсан" ажлын хэсгийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээний танилцуулга;

*Нийслэлийн Засаг дарга бөгөөд  
Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар,*

4. Гадаад улс орноос эх орондоо ирэх хүсэлт гаргасан иргэдийг татан авах тусгай үүргийн нислэгийн хуваарь, тусгаарлах байрны нэмэлт сонголт бий болгох боломжийн тухай;

*Гадаад харилцааны яамны  
Консулын газрын захирал Л.Мөнхтүшиг,*

5. Монгол орны зүүн бүс нутгийн газар хөдлөлтийн төлөв байдал, Газар хөдлөлтийн зарлан мэдээллийн тухай;

*ШУА-ийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн  
захирал, академич С.Дэмбэрэл,*

6. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар;

*Байнгын ажиллагаатай зөвлөлийн нарийн бичгийн дарга,  
хурандаа Б.Мандахгэрэл,*

7. 2020-2021 оны Өвлийн цаг агаарын тойм, Хаврын эхэн сарын цаг агаарын урьдчилсан төлөв байдлын талаар;

*Цаг уур, орчны шинжилгээний газрын  
дарга С.Энхтүвшин,*

8. Эргүүл, хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын үүрэг гүйцэтгэлтийн нөхцөл байдал;

*Шуурхай штабын дарга,  
хурандаа Б.Ууганбаяр,*

9. Аюултай болон эмнэлгийн хог хаягдал, суурин болон явуулын шинжилгээний цэгүүдэд хяналт шалгалт явуулсан дүнгийн талаар;

*Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын  
дарга Л.Эрдэнэчулуун,*

10. Замын хөдөлгөөний нөхцөл байдлын товч мэдээлэл;

*Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын дарга,  
цагдаагийн хурандаа С.Жавхлантбаатар.*

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

*Нэг: Гадаад харилцааны сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Батцэцэг,*

*Зам, тээврийн хөгжлийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,*

*Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд,*

*Шуурхай штабын дарга, хурандаа Б.Ууганбаяр нарт:*

1.1. 2021 оны 3, 4 дүгээр саруудад гадаад улсаас эх орондоо ирэх хүсэлт гаргасан иргэдийг татан авах төлөвлөгөөг баталж, сард 10-14 удаагийн тусгай үүргийн нислэг үйлдэх бэлтгэл ажлыг хангах;

1.2. Тусгай үүргийн нислэгийн тийзний үнийг хөнгөлөхтэй холбоотой зохицуулалтыг хийх;

1.3. Гадаад улсаас эх орондоо ирэх иргэдийг тусгаарлах байрны хүрэлцээг нэмэгдүүлж, тусгаарлах байрны орчин нөхцөл, үйлчилгээний чанар, төлбөрийн нөхцөлөөс хамаарч 3 түвшинд хувааж, иргэдэд тусгаарлах байрыг өөрөө сонгох боломжийг бүрдүүлэх;

1.4. Тусгаарлалтын хоногийн тоог багасгах, гэрээр тусгаарлаж, тусгаарлагдсан иргэдийг технологийн шийдэл, цахим хэлбэрийг ашиглан хяналтад байлгах ажлыг зохион байгуулж, нөхцөлийг бүрдүүлэх;

1.5. Вакцин хийлгэсэн болон гадаадаас ирэх ажиллах хүч, хөрөнгө оруулагчдыг коронавируст халдвар /КОВИД-19/-ын халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж нэвтрүүлэх, бизнес хөрөнгө оруулалтын салбарыг дэмжих ажлыг зохион байгуулах;

Хоёр. Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг үйлдүүлэн зохицуулах  
Байнгын ажиллагаатай зөвлөл,

Сангийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Жавхлан,

Барилга хот байгуулалтын сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Мөнхбаатар,

Улсын онцгой комиссын орлогч дарга,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбаян,

Нийслэлийн Засаг дарга бөгөөд

Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт.

2.1. Засгийн газрын "Газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2018 оны Н/206 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг Улсын онцгой комисст танилцуулах;

2.2. Газар хөдлөлтийн бичил мужлалын зураг (9 аймгийн төв болон томоохон хот суурин) хийж, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, орон сууцны барилгын чанарыг шалгах, дахин төлөвлөх, шинээр барих барилга, дэд бүтцийн сүлжээг гамшгаас хамгаалах шаардлагад нийцүүлэн төлөвлөлтийг хийх;

2.3. Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн идэвхижилтийг хянах 5 автомат станц байгуулах, "Богд", "Мандалговь", "Сэлэнгэ" станцад шаардлагатай багаж, төхөөрөмжийг суурилуулах;

2.3. Гамшгийн үед ашиглах хүнсний нөөцийн бүтээгдэхүүнийг хадгалах халаалт, хөргөлт бүхий хүнсний агуулахыг барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх;

2.4. Гамшгийн үед ашиглах нөөцийн шатахууны агуулахыг барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх;

Гурав Сангийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Жавхлан,

Улсын онцгой комиссын орлогч дарга,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Нийслэлийн Засаг дарга бөгөөд

Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар.

ШУА-ийн Одон орон геофизикийн хүрээлэнгийн захирал С.Дэмбэрэлд нарт:

3.1. Газар хөдлөлтийн аюулын зарлан мэдээлэх тогтолцоог сайжруулж, мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх ажиллагааны туршилтын үр дүнг 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр Улсын онцгой комисст танилцуулах;

3.2. Газар хөдлөлтийн аюулыг зарлан мэдээлэх тогтолцооны техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор газар хөдлөлтийг бүртгэх шинэ 5 станцын тоног төхөөрөмж, газар хөдлөлтийг бүртгэх станцуудын сэлбэг хэрэгслийн зардлыг төсөвт суулгах, Улаанбаатар хот орчмын газар чичирхийллийг бүртгэх 10 акселерометрийн станцын тоног төхөөрөмжийг суурилуулах зэрэг ажлын төсвийг боловсруулж, танилцуулах;

3.3. Газар хөдлөлтийн идэвхижилт ажиглагдаж буй Дорнод аймгийн Халх гол, Матад сумын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийг бүртгэх 5 станцын багаж төхөөрөмжийг худалдан авах суурилуулах ажлын хүрээнд тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай компанид холбогдох саналыг хүргүүлж, зохих арга хэмжээг авч Улсын онцгой комисст танилцуулах;

Дөрөв Цагдаагийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болдод:

4.1. Эргүүлийн үүрэг гүйцэтгэх алба хаагчдад үүрэг, даалгавар, чиглэл өгөхдөө нэг дор цуглуулж бөөгнөрөл үүсгэхгүйгээр зохион байгуулах;

4.2. Улсын онцгой комиссоос гарсан шийдвэр, дүрэм, журмыг хэрэгжүүлэх явцад ямар нэг алдаа, ойлголтын зөрүү гаргахгүй байх, тэдгээртэй холбоотой бүх шатны уялдаа холбоог хангаж, тодорхой дүрэм, журмын дагуу нэг ойлголттойгоор мөрдүүлэх;

Тав. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Бат-Эрдэнэд:

5.1. Хүнсний худалдааны төвүүдийн үйл ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан зохиомол үнийн өсөлт үүсэхээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг эрчимжүүлэх, зөрчил дутагдал гаргасан тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдэд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцож, олон нийтэд тухай бүр мэдээлж ажиллах;

Зургаа Эрүүл мэндийн сайд  
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд,

Гадаад харилцааны сайд  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Батцэцэг,

Шуурхай штабын дарга, хурандаа Б.Ууганбаяр нарт:

6.1 Вакцин хийлгэсэн иргэдэд олон улсын стандартад нийцсэн паспорт, дээтрийг олгох асуудлыг судалж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч Улсын онцгой комисст танилцуулах;

6.2. Гадаад улсаас эх орондоо ирсэн иргэд болон коронавируст халдвар /КОВИД-19/ авсан иргэд, ойр болон дам хавьтлыг гэрээр тусгаарлах, цахимаар зөвлөгөө өгөх, эмчлэх түр журам боловсруулж, 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн дотор танилцуулж, батлуулах.

ДАРГА



С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА

Т.МӨНХДОРЖ